




ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2020 оны аравдугаар сарын
байдлаар





ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО 2020 оны 10 сарын байдлаар



2020 оны эхний 10 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 18701 хүнд 5762,7 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна.




ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

Ажлын үндэсний статистик

Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд, 2020 оны 10 сарын байдлаар, сумаар



аймгийн хэмжээнд **127**



Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 127 ажил хайгч иргэн ногдож байхад Дэлгэрцогт 136, Дэрэн 142, Говь-Угтаал 434, Цагаандэлгэр 332, Баянжаргалан 221, Өндөршил 282, Гурвансайхан 147, Хулд 153, Дэлгэрхангай 133, Адаацаг 148 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг


БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН ТОО,
жил бүрийн 10 сарын байдлаар



БҮХ ХЭРЭГ



ХОЛБОГДОГЧ



Цагдаагийн хэлтсийн 2020 оны 10 сарын байдлаар Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг 183 болж өмнөх оны мөн үеэс 5 хэргээр буюу 2.7 хувиар гэмт хэргийн гаралт буурсан байна. Гэмт хэрэгт нийт 106 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 холбогдогчоор буюу 9.3 хувь өссөн.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг

Аймгийн хэмжээний зөрчил шийтгэл ногдуулсан байдал




Нийт зөрчил



Тээврийн хэрэгсэл
жолоодох эрх хасч,
торгосон



Эрүүлжүүлэгдсэн хүн



Аймгийн хэмжээнд 2020 оны 10 сарын байдлаар 16292 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 1447 зөрчлөөр буюу 8.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 16010 иргэнийг 486.2 мянган төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 206 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 80 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна. Нийт 388 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 169 хүн буюу 30.8 хувиар буурсан байна.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Ард түмэн


	Амаржсан эхийн тоо	Амьд төрсөн хүүхдийн тоо	0-1 насны хүүхдийн эндэгдэл	1-5 насны хүүхдийн эндэгдэл
2018 I-X	766	773	6	10
2019 I-X	768	776	4	6
2020 I-X	738	744	6	8

2020 оны 10-р сарын байдлаар 738 эх төрсөн ба нийт 744 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 32 төрөлтөөр өссөн байна. Төрсөн эхчүүдийн 90.2 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар 0-5 насны хүүхдийн 8 эндэгдэл гарсан байна.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Бүртгэгдсэн халдварт өвчлөлийн тоо



Халдварт өвчний 235 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 50.4 болж өмнөх оны мөн үеэс 71 тохиолдол буюу 15.3 пунктээр буурсан байна



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд



Эмнэлэгт эмчлэгдэж гарсан хүний тоо, амбулаторийн үзлэгийн тоо

	2018 I-X	2019 I- X	2020 I-X
Эмчлэгдэн гарсан хүний тоо	9142	8968	8380
Амбулаторийн үзлэгийн тоо	142231	144450	155766

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 8388 эмчлүүлэгч хэвтэж, 8380 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 57968 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.9 байна. 2020 оны 10 сарын байдлаар 155766 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 30.8%, өвчний учир амбулаторийн үзлэг 48.7%, идэвхтэй хяналт 15%, гэрийн идэвхтэй үзлэг 3.8 %, гэрийн дуудлагын үзлэг 1.3%- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 34.7 хувь нь эрэгтэй, 65.3хувь нь эмэгтэй хүн байна.




ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

АТГАМГАР
ТӨСӨВ



төсвийн орлогод эзлэх хувь 2020 оны 10 сарын байдлаар





АТГАЛГА
МОНГОЛ



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Банк

МОНГОЛ БАНК МЭДЭЭ / сая төгрөг /



2019 Х

2020 Х

62 567.3

НИЙТ ХАДГАЛАМЖ

82 665.0

119 464.2

ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ


117 598.6

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар буурч, 117 598.6 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 386.6 сая төгрөг, чанаргүй зээл 1 411.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 59.9 хувиар, чанаргүй зээл 1.8 хувиар тус тус буурсан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1.5 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 32.1 хувиар өсч, 82 665.0 сая төгрөг болов.



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – АЖ ҮЙЛДВЭР

АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ /САЯ.ТӨГ/



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2020 оны 10 сарын байдлаар 6 178.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 14.9 хувиар буурсан байна.

Аж үйлдвэр




АТГАМҮӨДӨС
МҮБТН



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

Дундговь аймгийн хэрэглээний үнийн индекс
(өмнөх оны 12 сар =100)




- Тус аймагт 2020 оны 10 сарын байдлаар өмнөх оны 12 сартай харьцуулахад хэрэглээний үнийн индекс 3.6 хувиар өсжээ. Хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 3.1 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 5.1 хувиар, хувцас бөс бараа гутал 7.3 хувь, орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлш 3.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 8.2 хувиар, эм тариа эмчилгээний бүлэг 4.7 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, /ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАНААР/



Тус аймагт 2020 оны 10 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний үнийн индекс 5.6 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 6.8 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 5.3 хувиар, хувцас бэс бараа гутлын бүлэг 11.2 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 4.4 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 10.2 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 4.9 хувиар өссөн, тээврийн бүлэг 3.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.



АТГАМГАД ТУУЛ



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах тоглоом



Валютын ханш



1212.mn аппликейнаас
СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС